



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/33/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020 Цахим хаяг: Kherlenchimegch@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020 о. 12 № 1-6/149

танай _____-ны № _____-т

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
ГАЗРЫН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ГАЗРЫН ДАРГА Б.БАТДУЛАМ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	104.8	98.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	958.2	897.4
	Нийт хөрөнгийн дүн	1,063.0	996.0
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,063.0	996.0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,063.0	996.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	618.1	564.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	653.7	628.0
	Үйл ажиллагааны үр дүн	(35.6)	(64.0)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(18.6)	(3.0)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(54.2)	(67.0)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,117.2	1,063.0
	Тайлант оны үр дүн	(54.2)	(67.0)
	Эцсийн үлдэгдэл	1,063.0	996.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	567.0	533.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	567.0	533.0
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	491.1	485.4
	Урсгал зардал	486.1	484.4
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	567.0	533.0
	Улсын төсвөөс санхүүжих	567.0	533.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газар нь дараах үндсэн чиг үүрэгтэй. Үүнд,

- Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол улсын виз, визийн зөвшөөрөл олгох, тус улсад байх визийн хугацааг сунгах, визийг хүчингүй болгох,
- Монгол Улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг бүртгэх, оршин суух зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацааг сунгах, хэлбэр, төрөл өөрчлөх, хүчингүй болгох, гадаадын иргэнийг цахим үнэмлэх олгох,

- Иргэний харьяалал, цагаачлал, олон улсын болон гадаадын улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газартай холбоотой асуудлыг шийдвэрлэх, гадаадын иргэн, гэр бүлд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх.

Тус байгууллага нь “Эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, Олон улсын жишигт нийцсэн цахим суурьтай виз, бүртгэл, хяналтын тогтолцоог бий болгох, гадаадын иргэдийн мэдээллийн нэгдсэн сан бий болгох” гэсэн стратеги зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох журмуудад нэмэлт, өөрчлөлт орсон байна. Үүнд, Монгол Улсын виз олгох журам, Гадаадын иргэн Монгол улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам, Гадаадын иргэнийг Монгол улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам, Улсын тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай журам.

Олон улсын стандартад нийцсэн цахим суурьтай виз, бүртгэл, хяналтын тогтолцоог бий болгох хүрээнд 2021 онд шинээр нэвтрүүлж буй үйлчилгээний хураамж төлөх “Гэрэгэ киоск” пос машиныг ашиглаж эхэлсэн.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тус байгууллагын албан өрөө тасалгаанд урсгал засварын ажлыг гүйцэтгэсэн ба үүнд 1 давхрын цонхны засварын ажилд 19.2 сая төгрөгийг, нэг цэгийн үйлчилгээний өрөөний засварын ажилд 19.9 сая төгрөгийг, дотор дулааны шугамын засварын ажилд 18.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 525.2 сая төгрөгийн 11 гүйлгээ, зарлагын 56.8 сая төгрөгийн 6 гүйлгээ, худалдан авах ажиллагааны 67.9 сая төгрөгийн 6 мэдээлэл, хөрөнгө, төсөв зарцуулахтай холбоотой 103.6 сая төгрөгийн 25 тушаалыг шилэн дансны цахим системд байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авах ажиллагаатай холбоотой 20.6 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна. Төсөв зарцуулах 2.5 сая төгрөгийн 3 тушаалыг хугацаа хоцроож байршуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах чухал асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 3.9 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрч, аудитын явцад 1 алдааг залруулж, 3.9 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, үнийн дүнгүй 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа: Албан хаагчдын цалингаас суутгасан 51.8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шийтгэл, хувь хүний орлогын албан татвар, цалингийн урьдчилгаа болон бусад суутгалыг цалингийн өглөг дансанд тусгахгүйгээр бүртгэсэн байна.

Албан шаардлага: Тайлант онд тус байгууллага нь 3.9 сая төгрөгийн төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал, бараа үйлчилгээний бусад зардлыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, гутал, хаалга, ус буцалгагч, засварын материал худалдан авахад зарцуулсан.

Зөвлөмж: Тус байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 50 нэр төрлийн 100.2 сая төгрөгийн 72 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Иймд эдгээр хөрөнгийн чанар байдалд үндэслэн хөрөнгийг актлах, дахин шинээр үнэ тогтоож цаашид ашиглах асуудлыг шийдвэрлэх.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	3	3.9	1	-	-	-	1	3.9	1	-
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	3	3.9	1	-	-	-	1	3.9	1	-

